

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Манай улсад нефть нэрэх үйлдвэр байдаггүй боловч сүүлийн жилүүдэд шатахууны түүхий эдийн импорт өсчээ. Ялангуяа керосин, нафта зэрэг газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүний импорт 2015 оноос огцом өсч байна. Энэ нь нефть үйлдвэрлэл, борлуулалтын үйл ажиллагаа явуулдаг зарим компани хуурамч шатахуун үйлдвэрлэж, шатахуун түгээх станцуудад нийлүүлж байгаатай холбоотой юм. Албаныхан болон хууль хяналтынхан энэ байдлыг мэдэж байгаа боловч шийдвэртэй алхам хийхгүй байна. Тэдгээр компаниудын хууль бус үйл ажиллагаа сүүлийн хэдэн жил үргэлжлэн иргэдийг хуурамч шатахуунаар ханган эдийн засаг, эд хөрөнгөөр нь хохироож ирлээ.

2018 онд газрын тосны бүтээгдэхүүний нийт импортын 17 хувийг дайвар бүтээгдэхүүн эзэлсэн байна. Манай улсад энэ төрлийн бүтээгдэхүүний импорт илт өссөн үе нь газрын тосны бүтээгдэхүүний татвар нэмсэн хугацаатай давхцдаг. Ийнхүү шатахуун импортлоход татварын дарамт нэмэгдэж, ам.долларын ханш чангарсанаар, гадаад валютаар худалдан авдаг бүтээгдэхүүнээ төгрөгөөр борлуулдаг импортлогчдод хүнд тусч, алдагдал хүлээх болжээ. Тооцооллоор шатахууны өртгийн 51 хувийг импортын худалдан авалт, 34 хувь нь татвар, 16 хувь нь үйл ажиллагааны бусад зардал эзэлдэг аж. Ийнхүү ашгийн хэмжээ нь хумигдсан зарим аж ахуйн нэгж хуулийн цоорхойг ашиглах болсон байна. Учир нь газрын тосны үйлдвэрлэлийн завсрын бүтээгдэхүүний импортод татвар ногдуулдаггүй. Онцгой албан татварын тухай хуульд ч энэ тухай зохицуулалт байхгүй. Мөн харьцангуй аюултайд тооцогдох энэ төрлийн бодис импортлоход тусгай зөвшөөрөл ч шаарддаггүй. Энэ нь хуурамч шатахуун үйлдвэрлэх боломжийг олгож байгаа юм.

Ийм үйл ажиллагаа явуулж буй компаниуд завсрын бүтээгдэхүүнийг үйл ажиллагаандаа ашигласныхаа төлөө нэг ч төгрөгийн татвар улсад төлөхгүй байна. 2017, 2018 онуудад Монгол Улсын хилээр хуурамч шатахуун үйлдвэрлэлийн гол түүхий эд болох 202 мянган тонн бодисыг оруулж ирсэн мэдээ байна.

Үүнээс харахад л сүүлийн хоёр жилд эдгээр нефтийн төрлийн бүтээгдэхүүнээс гаалийн албан татварт 3.6 тэрбум, онцгой албан татварт 55.6 тэрбум, хямдралтай үнээр импортолсон шатахуун, дизелийн түлшинд ногдох гаалийн болон НӨАТ-т 3.8 тэрбум, нийтдээ 63.0 тэрбум төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлэх боломжтой байжээ. Ийнхүү Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар татварын бааз сууриа тэлж, улсын төсвийн орлогыг өсгөөд зогсохгүй хуурамч шатахууны үйлдвэрлэлийг хязгаарлаж, иргэдээ олон тэрбум төгрөгийн өрөнд оруулахгүй, тэдний эрх ашгийг хамгаалах арга хэрэгсэл болох юм.

Хоёр. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл 5 заалттай. Керосин, хийн конденсатын нэрмэл дистиллят, хөнгөн фракцын бензин буюу нафта... зэрэг газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн болох бодисуудыг шатахуунтай найруулаад зах зээлийн үнээс хямдаар зах зээлд нийлүүлж байна. Шатахууныг дээрх бодисуудаар шингэлэн найруулж, арвижуулаад чанаргүй, хуурамч шатахуун болгодог. Ийнхүү найруулсан шатахуун нь машины бензин насос, явах эд ангийг эвдэж иргэдэд асар их хохирол учруулж байгааг шийдвэрлэх зорилгоор Онцгой албан татварын тухай хуульд зарим нэг өөрчлөлтийг оруулж байна. Мөн ийм үйл ажиллагаа явуулж буй компаниуд дээрх бодисуудыг үйлдвэрлэлд ашигласныхаа төлөө татвар төлөхгүй байгаа асуудлыг нэг мөр цэгцлэх зорилготой юм.

Гурав. Онцгой албан татварын тухай хууль батлагдсанаар үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагаврын талаар

Хуулийн төсөл батлагдсанаар иргэд чанартай шатахуун хэрэглэнэ. Мөн улсын төсөвт төвлөрөх татварын хэмжээ нэмэгдэх боломжтой юм. Улс орны эдийн засагт ямар нэгэн сөрөг үр дагавар үүсэхгүй, харин иргэдийг хуурамч бүтээгдэхүүн хэрэглэхээс сэргийлж, тэдний өмч хөрөнгийг хамгаалахад чиглэнэ. Хэрэглэгчид чанартай шатахуунаа зах зээлийн үнээр л худалдаж авна.

Дөрөв. Онцгой албан татварын тухай хууль батлагдсантай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт орох хуулиуд

Хуулийн төсөл Үндсэн хууль болон бусад хуульд нийцэж байгаа бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр хуульд нэмэлт өөрчлөлт орохгүй бөгөөд дагалдах хууль батлахгүй.

--- оОо ---

ХУУЛЬ САНААЧЛАГЧ